



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn

Аудитын менежер :Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: Boldbaatar.kh@audit.gov.mn

Аудитор: Д.Пүүжмаа

Утас:99080797

Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>ЗДТГ</b>	Засаг Даргын Тамгын Газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.19 № 56.  
талай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДӨРВӨЛЖИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА В.УРАНЧИМЭГ-Т

### СӨРӨГ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газар нь шатахуун зардлыг нормоос илүү зарцуулсан, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, орон нутгийн төсвөөс нэмэлт төсөв хуваарилсан, засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, цалин амралтын мөнгийг алдаатай тооцоолон олгосон байна. Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, тухай хуулийн 51 дүгээр зүйлийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/191 дүгээр тушаалын хавсралтын 3.4.ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно гэсэн заалт, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 48.3 сая төгрөгийн өртөг бүхий автомашиныг акталж данснаас хасах шийдвэр гараагүй байхад шинээр худалдан авсан автомашины зөрүүд шилжүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн

02.19.2024

гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын хүрээнд зарцуулаагүй, шилдэг байгууллагын шагналыг жилд 2 удаа олгосон, тээвэр шатахууны зардлыг нормд зааснаас илүү тооцоолон зарцуулсан, татварын давсан орлогыг зориулалт бусаар зарцуулан аялалд явсан байгууллагаас сургалтын төлбөр, томилолтын зардлыг төлүүлсэн, томилолтыг зөрүүтэй тооцоолон авсан, албан хаагчдад амралтын цалинг илүү дутуу тооцоолон олгосон, төсвийг зориулалт бус үрэлгэн зарцуулсан, төрийн аудитын байгууллагаас өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлээгүй зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Шилэн дансны цахим мэдээллийн системд байгууллагын урсгал санхүүжилт, хөрөнгө зарцуулах шийдвэрүүдийг тухай бүр мэдээлээгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>33,899,907.35</b>	<b>32,623,641.14</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>8,260,974.35</b>	<b>6,259,408.14</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	72,418.35	402,099.49
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	128,556.00	128,556.00
335	Бусад авлага	8,060,000.00	5,728,752.65
3351	Байгууллагаас авах авлага	-	668,752.65
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,060,000.00	5,060,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>25,638,933.00</b>	<b>26,364,233.00</b>
351	Түүхий эд материал	9,633,453.00	10,553,953.00
35110	Тусгай зориулалттай материал	9,633,453.00	10,553,953.00
354	Хангамжийн материал	16,005,480.00	15,810,280.00
35410	Бичиг хэргийн материал	2,224,200.00	2,077,000.00
35420	Аж ахуйн материал	5,224,180.00	5,224,180.00
35470	Бусад хангамжийн материал	8,557,100.00	8,509,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>767,493,135.50</b>	<b>827,594,741.49</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>767,493,135.50</b>	<b>827,594,741.49</b>
392	Биет хөрөнгө	756,374,468.77	816,855,241.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,037,967,030.39	1,037,967,030.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(437,133,927.60)	(488,719,963.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,544,800.00	97,544,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(68,871,050.52)	(83,816,049.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,151,618.80	155,770,618.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(123,199,728.89)	(131,875,528.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,092,236.00	41,092,236.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,236,703.41)	(36,072,235.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	97,851,960.00	235,917,320.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,960,866.00)	(11,177,086.00)
39217	Ном	169,100.00	224,100.00
393	Биет бус хөрөнгө	11,118,666.73	10,739,500.00
39301	Програм хангамж	2,600,000.00	2,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,033,333.27)	(2,412,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,552,000.00	10,552,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>801,393,042.85</b>	<b>860,218,382.63</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,575,931.25</b>	<b>2,887,522.87</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,575,931.25</b>	<b>2,887,522.87</b>
413	Өглөг	7,575,931.25	2,887,522.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,622,242.87
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,664,651.25	354,000.00
4136	Бусад өглөг	3,911,280.00	911,280.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,911,280.00	911,280.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>793,817,111.60</b>	<b>857,330,859.76</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	793,817,111.60	857,330,859.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	812,019,150.39	812,019,150.39
51101	Өмч: - төрийн	812,019,150.39	812,019,150.39
512	Хуримтлагдсан үр дүн	(311,544,953.43)	(248,031,205.27)
51210	Өмнөх үеийн үр дүн	(350,613,431.16)	(371,125,105.43)
51220	Тайлант үеийн үр дүн	39,068,477.73	123,093,900.16
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,342,914.64	293,342,914.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>801,393,042.85</b>	<b>860,218,382.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>651,762,210.00</b>	<b>870,124,967.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>94,968,110.00</b>	<b>203,450,000.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	94,968,110.00	203,450,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,968,110.00	203,450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,150.00	3,750,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	94,951,960.00	199,700,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>556,794,100.00</b>	<b>666,674,967.80</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>663,502,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	663,502,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,969,200.00	3,172,567.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,969,200.00	3,172,567.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	547,824,900.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	547,824,900.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>611,271,055.24</b>	<b>747,031,067.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>611,271,055.24</b>	<b>747,031,067.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>472,339,832.86</b>	<b>639,899,795.68</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,079,688.67	348,303,763.26
210101	Үндсэн цалин	179,625,504.67	236,445,720.89
210102	Нэмэгдэл	26,454,184.00	95,913,698.42
210104	Урамшуулал	-	15,944,343.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,464,980.67	43,561,426.69
210201	Тэтгэврийн даатгал	28,433,021.65	30,072,710.89
210202	Тэтгэмжийн даатгал	3,291,794.14	3,447,573.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,633,433.38	2,783,956.92
210204	Ажилгүйдлийн даатгал	646,067.41	676,289.47
210205	Эрүүл мэндийн даатгал	6,460,664.09	6,580,896.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,348,610.28	45,270,793.54
210301	Гэрэл, цахилгаан	8,169,748.93	10,727,273.54
210302	Түлш, халаалт	45,178,861.35	34,543,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,354,855.90	29,340,036.18
210401	Бичиг хэрэг	2,140,448.00	3,049,600.00
210402	Тээвэр, шатахуун	23,362,492.90	21,609,776.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,256,250.00	3,380,660.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,595,665.00	1,300,000.00
2105	Нормативт зардал	67,650.00	48,000.00
210502	Хоол, хүнс	67,650.00	48,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,355,850.00	3,928,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,250,000.00	341,500.00
210604	Урсгал засвар	16,105,850.00	3,587,400.00

2107	Томилолт, зочны зардал	6,208,000.00	11,707,100.00
210702	Дотоод албан томилолт	6,208,000.00	11,707,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,296,895.00	97,356.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,988,550.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	142,100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,863.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	58,182.00	-
210807	Газрын төлбөр	138,300.00	97,356.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,163,302.34	157,642,420.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,830,309.00	70,273,338.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,229,700.00	1,676,840.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,103,293.34	85,692,242.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,931,222.38	107,131,271.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,432,000.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,197,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,235,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133,499,222.38	106,631,271.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	130,939,472.38	106,115,023.24
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэх	2,559,750.00	516,248.72
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>40,491,154.76</b>	<b>123,093,900.16</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,422,677.03</b>	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,422,677.03	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(1,422,677.03)</b>	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>39,068,477.73</b>	<b>123,093,900.16</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>559,310,250.00</b>	<b>670,424,967.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,516,150.00</b>	<b>3,750,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,516,150.00</b>	<b>3,750,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,516,150.00	3,750,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,150.00	3,750,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,500,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>556,794,100.00</b>	<b>666,674,967.80</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	663,502,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	663,502,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,969,200.00	3,172,567.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,969,200.00	3,172,567.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	547,824,900.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	547,824,900.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>541,750,350.00</b>	<b>664,750,967.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>541,750,350.00</b>	<b>664,750,967.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>402,819,127.62</b>	<b>557,619,695.84</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,164,787.69	342,828,429.22
210101	Үндсэн цалин	218,415,485.69	228,730,159.42
210102	Нэмэгдэл	2,749,302.00	100,997,061.85
210104	Урамшуулал	-	13,101,207.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,452,300.00	47,744,199.00
210201	Тэтгэврийн даатгал	18,107,000.00	32,587,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,110,900.00	3,833,799.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,658,700.00	3,091,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	422,200.00	708,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,153,500.00	7,523,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,253,899.93	49,034,256.54
210301	Гэрэл, цахилгаан	7,684,533.11	10,727,273.54
210302	Түлш, халаалт	42,569,366.82	38,306,983.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,235,610.00	25,427,477.08
210401	Бичиг хэрэг	2,858,560.00	2,635,400.00
210402	Тээвэр, шатахуун	15,978,300.00	18,060,917.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,256,250.00	3,380,660.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,117,500.00	1,350,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,287,450.00	3,765,400.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	6,580,000.00	632,000.00
210604	Урсгал засвар	15,707,450.00	3,133,400.00
2107	Томилолт, зочны зардал	5,930,000.00	11,353,100.00
210702	Дотоод албан томилолт	5,930,000.00	11,353,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,921,009.00	97,356.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,612,664.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	142,100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426,863.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	58,182.00	-
210807	Газрын төлбөр	138,300.00	97,356.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,574,071.00	77,369,478.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,492,171.00	74,973,638.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,081,900.00	2,395,840.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>138,931,222.38</b>	<b>107,131,271.96</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,432,000.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,197,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,235,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133,499,222.38	106,631,271.96
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	130,939,472.38	106,115,023.24
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэн шилжүүлэх	2,559,750.00	516,248.72
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>17,559,900.00</b>	<b>5,674,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>17,559,900.00</b>	<b>5,674,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,559,900.00</b>	<b>5,674,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	17,559,900.00	5,674,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,559,900.00	5,674,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(17,559,900.00)</b>	<b>(5,674,000.00)</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	812,019,150.39	293,888,510.28	351,159,026.80	0.00	754,748,633.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	545,595.64	0.00	545,595.64
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	812,019,150.39	293,888,510.28	350,613,431.16	0.00	755,294,229.51
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-545,595.64	0.00	0.00	-545,595.64
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	39,068,477.73	0.00	39,068,477.73
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	812,019,150.39	293,342,914.64	311,544,953.43	0.00	
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх	812,019,150.39	293,342,914.64	59,580,152.00	0.00	59,580,152.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	59,580,152.00	0.00	59,580,152.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	812,019,150.39	293,342,914.64	371,125,105.43	0.00	734,236,959.60
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	123,093,900.16	0.00	123,093,900.16
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	812,019,150.39	293,342,914.64	248,031,205.27	0.00	857,330,859.76

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,128,371,100.00	419,401,577.62	884,866,150.00	667,252,400.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,128,371,100.00	419,401,577.62	884,866,150.00	667,252,400.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,103,583,100.00	414,469,577.62	884,866,150.00	561,137,376.76
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	453,380,200.00	221,164,787.69	454,329,600.00	342,828,429.22
210101	Үндсэн цалин	453,380,200.00	218,415,485.69	363,453,100.00	228,730,159.42
210102	Нэмэгдэл	-	2,749,302.00	90,876,500.00	100,997,061.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт				
210104	Урамшуулал	-	-	-	13,101,207.95
210105	Гэрээт ажлын хөлс				
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх</b>	53,704,600.00	26,452,300.00	57,416,400.00	47,744,199.00
210201	Тэтгэврийн даатгал	36,817,400.00	18,107,000.00	39,220,800.00	32,587,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,221,800.00	2,110,900.00	4,548,900.00	3,833,799.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,377,400.00	1,658,700.00	3,639,100.00	3,091,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	844,400.00	422,200.00	909,800.00	708,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,443,600.00	4,153,500.00	9,097,800.00	7,523,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	111,861,800.00	50,253,899.93	59,564,700.00	49,034,256.54
210301	Гэрэл, цахилгаан	20,832,400.00	7,684,533.11	9,416,200.00	10,727,273.54
210302	Түлш, халаалт	91,029,400.00	42,569,366.82	50,148,500.00	38,306,983.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	132,836,800.00	27,935,610.00	33,769,800.00	23,986,896.00
210401	Бичиг хэрэг	8,171,000.00	2,558,560.00	5,540,600.00	2,635,400.00
210402	Тээвэр, шатахуун	37,744,400.00	15,978,300.00	22,179,500.00	16,565,336.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,501,400.00	3,256,250.00	4,250,700.00	3,380,660.00
210404	Ном, хэвлэл	-	25,000.00	299,000.00	55,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд з	78,420,000.00	6,117,500.00	1,500,000.00	1,350,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	177,543,600.00	39,847,350.00	19,250.00	9,384,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	144,383,600.00	23,380,000.00	8,400.00	6,251,000.00
210604	Урсгал засвар	33,160,000.00	16,467,350.00	10,850.00	3,133,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,860,000.00	5,930,000.00	12,860,000.00	11,353,100.00
210702	Дотоод албан томилолт	11,860,000.00	5,930,000.00	12,860,000.00	11,353,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	92,802,600.00	10,921,009.00	4,288,400.00	97,356.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,707,000.00	9,612,664.00	2,400,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	464,200.00	142,100.00	560,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	938,200.00	469,100.00	469,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,830,800.00	426,863.00	427,700.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	147,600.00	73,800.00	73,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	406,800.00	58,182.00	203,400.00	-
210807	Газрын төлбөр	276,600.00	138,300.00	138,700.00	97,356.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	31,400.00	-	15,700.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	69,593,500.00	31,964,621.00	262,618,000.00	76,708,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,700.00	26,882,721.00	259,214,600.00	74,312,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69,563,800.00	5,081,900.00	3,403,400.00	2,395,840.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24,788,000.00	4,932,000.00	-	106,115,023.24
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-	-	106,115,023.24
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	106,115,023.24
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24,788,000.00	4,932,000.00	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,591,000.00	4,197,000.00	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,197,000.00	735,000.00	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	941,750,100.00	547,824,900.00	671,122,700.00	663,502,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	941,750,100.00	547,824,900.00	671,122,700.00	663,502,400.00
122005	Орон нутгийн төсвөөс	941,750,100.00	547,824,900.00	671,122,700.00	663,502,400.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>3,172,567.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>3,172,567.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>3,172,567.80</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1,495,581.80
210402	Тээвэр, шатахуун	-	1,495,581.80
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	660,738.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	660,738.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	500,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>516,248.72</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		516,248.72
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	1,875,659.80
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	1,875,659.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,875,659.80

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Завхан аймгийн Дөрвөлжин сумын ЗДТГ нь харьяалагдах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

“Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх сум орон нутгаа хөгжүүлэх” гэсэн зорилгыг тавин ажиллаж байна.

2023 онд Дөрвөлжин сумын ЗДТГ-аас “Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх” гэж дэвшүүлсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлж, 4 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.7 хувиар, дүгнүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Дөрвөлжин сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, зэрэг хуулиудыг голлон мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжтой холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 132.4 сая төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Бараа материал	25,638.9	26,364.2	725.0
Үндсэн хөрөнгө	767,493.1	837,254.7	69,761.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>801,393.0</b>	<b>869,878.7</b>	<b>68,485.7</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	793,817.1	866,990.8	73,173.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>801,393.0</b>	<b>869,878.7</b>	<b>68,485.7</b>

Бараа материал дансны үлдэгдэл 0.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 31.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 30.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 199.7 сая, төсвийн 5.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, өмнөх онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар ирсэн хашааг 61,6 сая төгрөгөөр илүү орлогод тусгасныг залруулснаас шалтгаалж 68.5 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын дансны үлдэгдэл 867.0 сая төгрөг болж 73.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 524.6 сая , нийт зарлагыг 524.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, 75.0 сая төгрөгөөр өсгөн 599.6 сая төгрөгөөр баталсан байна. 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 54 тоот ИТХ-ын тогтоолоор төсвийг 84.9 сая төгрөгөөр тодотгон 684.5 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 68 арга хэмжээг санхүүжүүлэхээр 599.6 сая төгрөгийн төсөв баталсныг 636.6 сая орон нутгийн төсвөөс, дээд шатны төсөв захирагчаас 59.4 төгрөгийн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 614.5 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 49.0 сая төгрөг, нийт 663.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж, 106.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 663.5 сая төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 49.1 сая, багийн үйл ажиллагааны зардлыг 2.9 сая, Засаг даргын нөөц санг 7.8 сая, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг 45.1, мэдээлэл сурталчилгааны зардлыг 1.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	464,908.8	415,846.9	49,061.8	89.4
2	80106-Багийн үйл ажиллагаа	88,139.5	85,257.5	2,881.9	96.73
3	81102- Засаг даргын нөөц сан	57,194.0	49,327.6	7,866.4	86.25
4	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	73,060.3	27,955.4	45,104.8	38.26
5	80205 Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	0	1,200.0	0
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал				

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 2.4 сая, хагас жилийн мал тооллогын зардал 0.8 сая, нийт 3.2 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 0.7 сая, хангамжийн, бараа материалын зардалд 1.5 сая, бусад урсгал шилжүүлэгт 0.5 сая төгрөгийг зарцуулж, 0.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус байгууллагад тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Пүүжмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03/26 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 671.5 сая төгрөгийн 1.5 хувь буюу 7.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд оруулах ёстой мэдээллүүдээс 746.5 сая төгрөгийн 46 мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

*Шийдвэрлэсэн нь:*

*Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.*

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дөрвөлжин сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	803.0	1	803.0	100
Албан шаардлага	7	57,761.8	4	21,027.3	59
Зөвлөмж	1	424,192.1	1	424,192.1	100
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>482,756.9</b>	<b>6</b>	<b>446,022.4</b>	<b>86.3</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хөрөнгийн тооллогын асуудалд анхаарах шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 361.5 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 297.3 сая төгрөгийн алдааг залруулан, 2 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Үүнд: Аудитын явцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 199.7 сая, төгрөгийн шатаах зуухыг орлогод тусгаагүй байсныг, өмнөх онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар ирсэн хашааг 61,6 сая төгрөгөөр илүү орлогод тусгасныг, өглөгийг 36.0 сая төгрөгөөр илүү тусгасныг залруулан гаргууллаа.

Аудитаар нийт 64.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 48.3 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, 4.5 сая төгрөгд зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо, алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### **5.1 Төлбөрийн акт**

*Илрүүлэлт:* Татварын давсан орлогыг зориулалт бусаар зарцуулан аялалд явсан 7.7 сая, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан тасралтгүй боловсролын сургалтын төлбөр, томилолтын 0.4 сая төгрөгийг байгууллагаас төлүүлсэн, нягтлан бодогч томилолтыг 0.4 сая төгрөгөөр илүү тооцон авсан, албан хаагчдад амралтын цалинг 2.7 сая төгрөгөөр дутуу, 0.05 сая төгрөгөөр илүү тооцон олгосон нь:

Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 3.4.ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй байна.

### **5.2 Албан шаардлага**

*Илрүүлэлт:* Шилдэг байгууллагын шагналыг жилд 2 удаа зохион байгуулж 2.0 сая төгрөг зарцуулсан, санхүүчдийн баяр тэмдэглэх болон баярт оролцсон албан хаагчдад 1.6 сая төгрөгийн зардал гаргасан, тээвэр шатахууны зардлыг нормд зааснаас илүү тооцоолон 0.9 сая төгрөгийг зарцуулсан зэрэг нь:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал.

*Илрүүлэлт:*

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Татан буугдсан Шинэ Дөрвөлжин ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгүүдийг орлогод тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ",14.4.2".бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шинэ Дөрвөлжин ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгүүдийг хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж данс бүртгэлд тусгах

Илрүүлэлт:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас олгосон авто тээврийн хэрэгслийг бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ",14.4.2"бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас олгосон авто тээврийн хэрэгслийг дахин үнэлгээ хийлгэж данс бүртгэлд тусгах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аудитын явцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн шатаах зуухыг орлогод тусгаагүй	1	199,700.0	1	199,700.0			1	199,700.0				
Өмнөх онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар ирсэн хашааг 61,6 сая төгрөгөөр илүү орлогод тусгасныг	1	61,634.6			1	61,634.6	1	61,634.6				
Өглөг илүү тусгасан	1	36,000.0			1	36,000.0	1	36,000.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>297,334.6</b>	<b>1</b>	<b>199,700.0</b>	<b>2</b>	<b>97,634.6</b>	<b>3</b>	<b>297,334.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө дутагдсан автотээврийн хэрэгсэл	1	48,300.0									1	48,300.0
Шилдэг байгууллагын шагналыг 2 удаа олгосон	1	2,000.0			1	2,000.0						
Санхүүчидын баяр тэмдэглэсэн	1	1,000.0			1	1,000.0						
Санхүүчидын баярын томилолт	1	584.0			1	584.0						
Тээвэр шатахууны зардлыг журамд зааснаас илүү тооцоолон зарцуулсан	1	915.0			1	915.0						
Татварын давсан орлогыг зориулалт бусаар зарцуулж аялалд явсан	1	7,700.0	1	7,700.0								
МНБИ-ээс зохион байгуулсан тасралтгүй боловсролын сургалтын төлбөр, томилолтыг байгууллагаас төлүүлсэн.	1	450.0	1	450.0								
Нягтлан бодогч томилолт илүү тооцоолон авсан	1	360.0	1	360.0								
Ажилчидад амралтын мөнгийг дутуу тооцоолон олгосон	1	2,847.8	1	2,847.8								
Ажилчидад амралтын мөнгийг илүү тооцоолон олгосон	1	48.9	1	48.9								
Шилэн дансанд 746.5 сая төгрөгийн 46 мэдээллийг оруулаагүй	1	0			1	0						
Татан буугдсан Шинэ Дөрвөлжин ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгүүдийг орлогод тусгаагүй	1	0					1	0				
Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас олгосон автотээврийн хэрэгслийг дахин үнэлэн бүртгэлд тусгаагүй	1	0					1	0				
Сөрөг санал дүгнэлт авсан учир	1	0							1	1		
<b>Дүн</b>	<b>14</b>		<b>5</b>	<b>11,406.7</b>	<b>5</b>	<b>4,499.0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>48,300.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/


Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дөрвөгжин сумын ЗДТГ	46	746,462.4	-	-	1	0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-

**БОЛОВСРУУЛСАН : АУДИТОР**

**ХЯНАСАН:**

**АУДИТЫН МЕНЕЖЕР**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



Д.ПҮҮЖМАА 2024.02.20

Х.БОЛДБААТАР 2024.02.21

Д.БАТ-УНДРАА 2024.02.21